

II. Монголын эртний түүхийн асуудлууд

МОНГОЛЫН ЭРТНИЙ УЛСУУДЫН ТҮҮХИЙН
ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛД

П.Дэлгэржаргал

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.
deegii2001mn@yahoo.com

Өгүүллийн товч утга: Монголын эртний улсуудын үечлэл болон Хүннү, Сяньбийн түүхийн үечлэлийг дахин нягтлан үзэж, үечлэлийн шинэ хувилбар санал дэвшүүлийг зорилго. 842 - 923/924 оны үеийг "Монгол Татарын хаант улс"-ын үе гэж нэрлэх саналыг дэвшүүлж байгаа болно.

Түлхүүр үг: Хүннү улс, Хүннү гүрэн, Сяньбийн нэгдсэн улс, Сяньби угсааны улс, Тоба, Тогон, Жоужань, Монгол-Татарын хаант улс

Монголын түүхийн судалгаанд, Монголын эртний улсуудын үе гэдэгт Хүннү гүрэн байгуулагдсан МЭӨ 209 оноос Хятан гүрэн мөхсөн 1125 он хүртэлх үе, эсвэл Монгол ханлиг аймгуудын үе (XI-XII зуун) хүртэлх үеийг үндсэн нь хамруулан ойлгож ирсэн.

Дорно зүгийн морьтон, янз бүрийн угсааны нүүдэлчдийн довтолгоонд эртний скифүүдээс эхлээд (МЭӨ IX-VII зуун) МЭ XV зуунд Орос дахь Монголчуудын ноёрхол унах хүртэл 2000 гаруй жил Европчууд нэрвэгдсэн. Тэдгээр нүүдэлчдийг Европын түүх бичлэгт Варварууд хэмээн нэрлэдэг.

Харин Төв Азийн нүүдэлчдийн мөнхийн хөрш хятадын суурин иргэд наанадаж МЭӨ V зуунаас морьтон дайчдын довтолгоонд өртөж эхэлсэн ажээ. Хан улсыг Хүннү нар байнга дарамтлан заналхийлж байжээ. МЭӨ 198 онд Хан улс арга буюу Хүннүг өөртэйгөө энэ чацуу улс мөн болохыг хүлээн зөвшөөрч, хоёр орны түүхэн хилийг цагаан хэрмээр тогтож, жил бүр алба барьж байхаар болсон юм. Хятад сурвалжид янз бүрийн нэрээр тэмдэглэгдсэн Төв Азийн эртний нүүдэлчдийн дундаас Хүннү, Дунху, Усунь, Динлин болон Юэжийн аймгийн холбоо, төр төстэй бүрдэл байгуулагдан, тэдгээрийн хооронд Төв Азид ноёрхохын төлөө тэмцэл өрнөжээ.

Нүүдэлчдийн байгуулсан улсуудыг төр улсын хэмжээнд хүрээгүй, chiefdom буюу толгойлогчийн эзэмшил, сайндаа л түрүү улсын түвшинээс хэтрээгүй, эсвэл нүүдэлчдийн улсыг суурин соёлын нөлөө гэх зэргээр тайлбарладаг түүх бичлэгийн дэг сургууль, үзэл баримтлал өрнөдөд хүчтэй хэвээр байна.

Эрт, дундад үеийн нүүдэлчдийн төр, нийгмийн зохион байгуулалтыг ойлгохын тулд "нүүдэлчдийн овог, аймаг"-ийн тогтолцоог нарийвчлан судлах шаардлага тулгарч байна. Ялангуяа, язгууртан ба язгууртан бус овгуудын харилцаа, язгууртан овгуудад эрх мэдэл төвлөрөх үзэгдэлд онцгой анхаарал тавьж судлууштай юм. Монголын эртний улсуудын төр нь язгууртан овгуудын ноёрхол дээр үндэслэж байсан гэж үзэж болно. Тэр овгийн ноёрхол унаж, өөр овог ноёрхохын хамт улсын нэр өөрчлөгдөх нь түгээмэл байсан бололтой.

Монгол нутагт байгуулагдсан аймгийн холбоо, төрийн бүрдлүүдээс хамгийн хүчирхэг нь Дунху, Хүннү, Юэжи байлаа. Тэдний төр ёсны хөгжил нэлээд өндөр түвшин, төр улсын хөгжлийн шатанд хүрсэн гэж үзэж болохоор байна. Сурвалжид тэмдэглэгдсэн анхны шаньюй Түмэн боловч түүнээс нэлээд өмнө Хүннүчүүд "шаньюй" өргөмжлөх болсон төдийгүй "шаньюй"-н угсаа залгамжлах ёс нэлээд нарийн тогтсон байжээ. "Түүхэн тэмдэглэл"-ийн 110 дугаар бүлэг "Хүннүгийн шастир"-т бичсэнээр "Түмэн шаньюйгийн орыг их хатны ууган хүү Маодунь залгамжлах ёстой байжээ. Гэтэл Түмэн шаньюй хайртай бага хатнаасаа төрсөн хөвгүүнээрээ өөрийгөө залгамжлуулах хүсэлтэй байсан учир Маодуныг зайлуулахаар шийдэн, Юэжи нарт барьцаанд явуулаад, түүнийг хорлох зорилгоор

Юэжийг гэнэт довтолжээ”¹. Гэвч Маодунь Юэжи нарын барьцаанаас оргон гарч, төрөлх нутагтаа ирж чадсан байна. Эцэг Түмэн шаньюй түүний эр зориг, авхаалж самбааг үнэлж арга буюу Маодуньд түмэн цэрэг өгч захируулжээ. Сурвалжийн дээрх мэдээнд, Түмэн шаньюй угсаа залгамжлах ёсыг зөрчихөөсөө эмээн арга мэх хэрэглэснийг өгүүлсэнээс үзэхэд Түмэнгээс өмнө шаньюйн угсаа залгамжлах ёс тогтож, шаньюйн институт хэлбэршин төлөвшсөн нь тодорхой байна. Дунху болон Юэжигийн төр ёсны хөгжил ч Хүннүгийнхээс дутахааргүй байсан бололтой. Энэ тухай сурвалжид “энэ үед дунху (东胡 donghu) аймгууд хүчирхэгжин, юэжи (月氏 yueshi) аймаг цэцэглэн мандаж байсан бөгөөд Хүннүгийн шаньюй (匈奴单于 xiongnu chanyu) Түмэн (头曼 touman) байв”² гэж тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн Хүннү, Дунхугийн хооронд улсын хилийн зааг нарийн тогтож, хил хамгаалалтын эх үүсвэр тавигдаж байсан талаар Сыма Цяны “Түүхэн тэмдэглэл”-д “Хүннү [Дунху]-ийн хооронд мянга гаруй газар (里 li) үргэлжлэх хүн нутагладаггүй зэлүүд газар буй. Түүний захаар тэд оуто (瓯脱 outuo) байгуулан сууцгаана”³ гэж тэмдэглэн үлдээжээ.

МЭӨ 209 онд тогтсон Хүннү гүрэн нь Хүннү болон эртний нүүдэлчдийн төр ёсны баялаг уламжлалд тулгуурлан байгуулагдсан нь тодорхой бөгөөд Маодунь шаньюйгийн хийсэн шинэтгэл ч үүнийг нотолдог. Төр ёсны баялаг уламжлалд тулгуурлахгүйгээр Маодунь шаньюй ийм том гүрнийг байгуулж, улсаа баруун, зүүн, төв гурван хэсэгт хуваан захирч, засаг захиргааны аравтын системийг үндэслэн бий болгож, төрийн байгууламжаа шинэчлэн, түшмэл ёсыг төлөвшүүлж, түшмэдийн зэрэг дэвийг нарийвчлан тогтоох (дөрвөн эвэртэн, зургаан эвэртэн нийт арван эвэртэн ван, арван дөрвөн түмтийн дарга бүгд хорин дөрвөн түшмэдүүд) зэрэг улс төр, нийгэм эдийн засгийн иж бүрэн шинэтгэлийг хийх боломжгүй юм⁴.

Маодунь шаньюй хүчирхэг Дунху нарыг бут цохисноор, Хүннүчүүд Төв Азид дангаар ноёрхох боломжтой болж, төрийн байгууламжаа улам боловсронгуй болгон, улс төр, нийгэм-эдийн засгийн иж бүрэн шинэтгэл хийснээр, Төв Азид төдийгүй дэлхий дахинд нэр алдраа дуурсгасан хүчирхэг Хүннү гүрнийг байгуулсанд түүний гавъяа оршино.

• Иймд МЭӨ 209 оноос өмнө Хүннү улс байгуулагдсан бөгөөд Маодунь шаньюйгийн үед Хүннү улс нь гүрэн болон өргөжсөн хэмээн үзэх нь түүхэн үнэнд илүү ойртоно хэмээн үзэж байна.

Бодит байдал ийм байсаар байтал, Маодунь Хүннүгийн шаньюй болсон МЭӨ 209 оныг судлаачид санал нэгтгэйгээр Хүннү улс байгуулагдсан он хэмээн үзсээр байна. Харин МЭ 93 онд Хүннү гүрэн мөхсөн гэдэг үзэл баримтлалыг сүүлийн үед эргэн харж, МЭ II зууны дунд үе хүртэл Хүннү улс оршин тогтнож байсан гэдэг саналыг судлаачид дэвшүүлэх болжээ.

Хүннүгийн төрийн түүхийг:

1. Хүннүгийн анхны төр улсын үе (МЭӨ V-IV зуунаас МЭӨ 209 он хүртэлх үе)
2. Хүннү гүрний үе (МЭӨ 209 оноос МЭ 93 он)
3. Хүннү гүрний задралын үе (МЭ 93 оноос 156 он)

¹ 史记 (shi ji), 卷110, 匈奴. 第2888页

² 史记 (shi ji) 卷110, 匈奴. 第2887页

³ 史记 (shi ji), 卷110, 匈奴. 第2889页

⁴ Дэлгэржаргал П. Монгол нутагт төр төстэй бүрдэл бий болсон түүхийн асуудалд. “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал”. УБ., 2001. т. 20

3. Хүннү нар хэд хэд хуваагдаж, бусдын нутагт төр улсаа байгуулж байсан үе (МЭ II зууны II хагасаас МЭ V зуун) хэмээн хуваан үзэж болмоор байна.

1971 онд Г.Сүхбаатар багшийн хэвлүүлсэн "Сяньби" нэгэн сэдэвт зохиол нь Монголд Сяньби судлалын эхийг тавьсан томоохон бүтээлд зүй ёсоор тооцогдоно. Харамсалтай нь үүнээс хойш манайд Сяньби судлал үндсэндээ хөгжөөгүй, зогсонги байдалд байна. Монгол улсын нутгаас Сяньби үед холбогдох археологийн дурсгал олдоогүй (магадгүй илрүүлж чадаагүй, эсвэл Хүннү булшнаас ялгахгүй байгаа байж болох юм) байгаа нь Сяньбийн судлалын хөгжилд сөргөөр нөлөөлдөг бололтой. Харин Өвөр Монголын нутгаас Тоба болон Муюн Сяньбийн түүхэнд холбогдох булш, бунхан олноор олддог нь БНХАУ-д Сяньбийн судалгаа төвлөрөх боломжийг олгож байна. Гэвч Хятад дахь Сяньбийн судалгаанд археологийн чиглэл давамгайлж байгаа бөгөөд Тоба Вэй (Умард Вэй), Тогон (Тугухунь)-ы улс төр, нийгэм эдийн засаг, соёлын талаарх судалгаа нь Хятад төвийн үзлийн үүднээс бичигдэх нь түгээмэл байдаг.

МЭ 220 онд Хожуу Хан улс мөхсөний дараа нүүдэлчид урагш түрж, хятадын нутагт өөрсдийн улсуудыг байгуулсанаар 20 орчим улс оршин тогтнож байснаас Сяньби угсааны есөн улс, Хүннү угсааны гурван улс байжээ. Хятадын түүх бичлэгт "Умардын таван аймгийн арван зургаан улсын үе" гэх энэ үеийг Хүннү угсааны Лю Юаньхай 304 онд Түрүү Жао (304-329) улсыг үндэслэн байгуулсанаар эхэлж, 439 онд Сяньби угсааны Тобачуудын байгуулсан Умар Вэй улс умард хятадыг нэгтгэснээр төгсгөдөг. Хятадын он дарааллын бичигт хүннү, цзеху, сяньби, ди, цян аймгийг "таван бүдүүлэг" (Wu hu) хэмээн нэрлэж байв. Хятадын түүх бичлэгт умард Хятадад ноёрхлоо тогтоож байсан нүүдэлчин улсуудын түүхийг Хятадынх болгон бичиж, мушгин гуйвуулсан байдаг ч гэсэн үнэн хэрэгтээ тэдгээр нь нүүдэлчдийн байгуулсан улсууд буюу хятад бус төрт улсууд байсан билээ. Михаэл Вайерсийн бичсэнээр "умрын эзэнт улсуудын тухайд Хятадын түүх бичлэг эргэлзээтэй байдгаас хятадын чухам ямар эх сурвалжийг (эдгээр нь сяньби нарын талаарх цорын ганц эх сурвалж бөгөөд бүгд хожуу үеэс гаралтай) баримталснаас шалтгаалаад 9 янзын Сяньби улс мэдэгдээд байгаагийн зургааг нь хятадын өөр өөр династи гэж үзсэн байдаг. Эдгээр Сяньби улсын газар нутаг түүхийн янз бүрийн үеүдэд Хянганы уулсаас Шинжаан мужийн гүнд хүртэл үргэлжилж байсан ба цаг хугацааны хувьд нийтдээ МЭ 156-431 оныг хамарна. Энэ бүх хугацаанд бие биеийн эсрэг дайтаж, улсаа булаалдаж харилцан тэмцэлдсэн нийт 42 хааны нүүр үзжээ"⁵.

Сурвалжаас үзэхэд, Сяньби аймгуудаас Цифү аймгууд Баруун Цинь улс (385-431), Түфа аймгууд Өмнөд Лян улс (397-414), Муюн аймгууд Түрүү Янь улс (337-370), Хожуу Янь улс (384-409), Баруун Янь улс (386-394), Өмнөд Янь улс (398-410), Түгүхунь нарын Тогон улс (285-663), Тоба аймгууд Умард Вэй улс (386-534), Хятан аймгууд Ляо улс (916-1125)-ыг тус тус үндэслэн байгуулж⁶, умард хятадад ноёрхож байснаас үзэхэд Дунхугийн угсааны монгол хэлт Сяньби аймгууд тухайн үеийн Төв Азийн улс төрийн тавцанд чухал үүрэг гүйцэтгэж байсан нь тодорхой байна. Үүн дээр Хүннүгийн зарим аймгуудын Умард Хятадад байгуулсан Түрүү Жао (304-325), Умард Лян (397-439), Ся (407-431) улсууд болон Вэй улс унасны дараа Юйвэнь аймгийн байгуулсан хожуу Жоу улс, Ухуань, Күмоси, Дуань зэрэг аймгуудын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, Жоужаний хаант улсын Төв Азийн түүхэнд эзлэх байр суурийг нэмж тооцвол тухайн үеийн Монгол угсааны аймгуудын эзлэх орон зай, хэмжээ далайц, төр ёс, угсаа-соёлын хөгжилд гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурь тодрон гарч ирж байна⁷.

⁵ Вайерс М. Морьтон угсаатнуудын омогшил – Чингис хааны "дэлхий дахины их гүрэн". – Чингис хаан хийгээд түүний өв. УБ., 2007. т. 57

⁶ Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Москва, 1984. с.4-5

⁷ Дэлгэржаргал П. Монголчуудын угсаа гарвал. УБ., 2005. 88 дахь тал

Ийнхүү Хожуу Хан улс мөхсөний дараа Сяньби болон Хүннү угсааны аймгууд хойд Хятадад ноёрхох болж, нүүдэлчдийн олон төр улс байгуулагдан, умард Хятадад ноёрхохын төлөө хоорондоо өрсөлдөж байсан нь түүхэн үнэн юм. Энэ тэмцэлд Сяньби угсааны Табгач нар ялж, бусад улсуудаа эрхшээлдээ оруулан, умард хятад болон өмнөд Монголыг нэгтгэсэн хүчирхэг умард Вэй улс байгуулжээ. Табгачийн Шийзянь 310 онд Табгачийн Дай улсыг үндэслэн байгуулж, одоогийн ӨМӨЗО-ын Хорин Гэр хошууны нутагт Шэнлэ хотыг нийслэл болгож, түүний дараа Табгач Гуй 386 онд ван болж, улсаа Вэй гэж нэрлэсэн нь түүхнээ Умард Вэй (386-534) гэж алдаршсан. Табгач нарын байгуулсан Умард Вэй улс нь хойд Хятад болон Өмнөд Монголд ноёрхлоо тогтоож байсан бөгөөд хожим нь Вэй улс задарч, Баруун Вэй (535-581) болон Зүүн Вэй (534-550) гэх хоёр улс болжээ. Сяньби угсааны Тугухунь аймгууд Хөх нуурт өөрсдийн улсыг байгуулж, МЭ VII зууны сүүлч хүртэл оршин тогтнож байв.

Энэ бүгдээс үзэхэд, гурван улс (220-280)-ыг нэгтгэн байгуулагдсан Баруун Зинь улсын нэгдэл дор хятад орон арав орчим жил л байсан бөгөөд "найман ноёдын үймээн" 15 жил (291-305) үргэлжилж, хойд хятадыг үгүйрүүлэн сүйтгэсэн тэр үеэс Сүй улс байгуулагдах хүртэл монгол угсааны аймгууд умард хятадад ноёрхож байсан гэж үзэж болно.

Хан улс мөхсөнөөс хойш (МЭ 220 он) хятадын нэгдмэл байдал алдагдсанаас өөрсдийн газар нутгийг хамгаалах чадваргүй болж, умард хятадыг нүүдэлчид эзэгнэх болжээ. Энэ байдал бүхэл бүтэн 300-аад жил үргэлжилсэн бөгөөд олон жил үргэлжилсэн тэмцэл тулааныг эцэс болгон, бусад нүүдэлчдийн улсуудаа нэгтгэн авсан Умард Вэй улс хятадын соёлын хөгжилд онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Энэ бол нүүдэлчид умард хятадыг нэгтгэн захирч, суурин иргэншлийн соёлын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан анхдугаар үе билээ. Умард Хятад дахь Тоба Вэй, Баруун болон Баруун хойд Хятад дахь Тогон улстай зэрэгцэн Монгол нутгаар төвлөрсөн Жоужань улс оршин тогтнож байв. Ийнхүү МЭ IV-VI зуунд Төв Азийн нутагт Сяньбийн угсааны гурван хүчирхэг улс зэрэгцэн оршиж байсан билээ.

Харин манай түүх бичлэгт, Сяньби угсааны эдгээр улсуудын түүхийн залгамж чанар, угсаа соёлын нэгдмэл байдлыг бүрхэгдүүлэн, хооронд нь салгаж, Сяньбийн улсыг II-IV зуунд, Жоужань улсыг IV-VI зуунд оршин тогтнож байсан гэж бичсээр ирсэн нь Монгол угсааны улсууд, түүний дотор Сяньбийн түүхийг санаатай болон санамсаргүйгээр хооронд нь зааглан салгаж, улмаар хоёр өөр угсаатан, хоёр өөр ард түмэн мэт ойлголтыг төрүүлэхэд хүргэж байна.

Бодит байдал ямар байв. МЭ 156 онд Таньшихуайн үндэслэн байгуулсан Сяньби улс 235 оны орчим задарч, бие даасан хэд хэдэн хэсэгт хуваагдсан ажээ. **Тэдгээрээс Умард Хятадад байгуулагдсан есөн улсаас Тоба нарын Умард Вэй, Тугухунь нарын Тогон улсууд, Монгол нутгаар төвлөрсөн Жоужань гэсэн гурван томоохон улс зэрэгцэн орших болсон. Иймээс эдгээр гурван улс бүгд Сяньби угсааны аймгуудын байгуулсан улс төдийгүй хүн ам, угсаа соёл, төр ёсны уламжлалын хувьд ч Сяньбийн үргэлжлэл юм.**

Иймээс Сяньбийн төрийн түүхийг:

1. Сяньби улс үүсч байгуулагдсан үе (МЭ 93 оноос 156 он)
2. Сяньбийн нэгдсэн улс буюу Сяньби гүрний үе (156 оноос 235 он)
3. Сяньбийн нэгдсэн улсын задралын үе (235 оны үеэс IV зууны эхэн үе)
4. Сяньбийн олон жижиг улс умард Хятадад ноёрхсон үе (IV зууны эхнээс V зууны эхэн үе)
5. Жужан, Умард Вэй, Тогон улсын үе гэж үечилж үзэх нь зүйтэй байна. Эндээс үзэхэд, Сяньбийн түүх нь Хүннү гүрэн задарч, Сяньби нар

Монгол нутагт өөрсдийн төр улсыг байгуулж эхэлсэн МЭ 93 оноос Тугухунь нарын Тогон улс мөхсөн МЭ VII зууны сүүл үеийг хүртэлх олон зууныг дамнасан, өргөн уудам газар нутгийг хамарсан түүхийг багтаах ажээ.

Хятадын сонгодог соёлыг бий болгосон гэж үздэг Тан улс (618-907)-ыг хятадын түүх бичлэгт Умар Вэй улсыг залгамжлагч, цэвэр хятад бус династи гэж үзэх явдал байдаг.

Монгол угсааны Хүннү, Сяньби, Жоужань улсууд ээлжлэн тогтож байгаад 555 онд Жоужань улсыг мөхөөн Түрэгийн хаант улс байгуулагдсанаар Түрэг угсааны улсууд монгол нутагт ноёрхох болжээ.

Руни бичгийн дурсгалууд нь VI-IX зууны Төв Азийн нүүдэлчин аймгуудын холбоо, бүрдлүүдийн талаар нэлээд бодитой мэдээллийг өгч байна. Эдгээр бичээсүүдэд "Татар"-ын талаар өгүүлж байгаа нь Рашид-Ад-Дины "Судрын чуулган"-ы "Татар"-ын тухай мэдээг давхар баталж байгаа хэрэг юм. Күл-тегиний хөшөөний бичээсийн зүүн талын 4, 14 дүгээр мөр, өмнө талын 1 дүгээр мөр, Билгэ хааны хөшөөний бичээсийн зүүн талын 5 дугаар мөрөнд тус тус Отуз Татар [ot(u)z t(a)t(a)r]-ын талаар, Билгэ хааны хөшөөний бичээсийн зүүн талын 34 дүгээр мөр⁸, Моюнчур ханы хөшөөний бичээсийн зүүн талын 13, 15 дугаар мөр⁹, Тариатын бичээсийн 11, 13, 23 дугаар мөр¹⁰, Хербис Баар (Кюлюг Йиге)-ын бичээсэнд¹¹ (Д.Д.Васильевынхаар "Тогуз Тата<...>"¹²) Тогуз Татар [t(o)γ(u)z t(a)t(a)r]-ын талаар тус тус өгүүлж байгаагаас гадна Узун оба (Зүүн овоо)-ын бичээсэнд "Татар" [t(a)t(a)r] гэдэг нэр¹³ дурьдагдаж байна.

Рашид-Аддины "Судрын чуулган"-аас үзэхэд, Төв Азийн нүүдэлчин овог аймгууд "Түрэг", "Татар", "Монгол" гэсэн ерөнхий нэрээр нэрлэгдэн алдаршиж байсан нь тодорхой байна. Рашид-Аддин Төв Азийн хээр талын нүүдэлчдийн түүхийг а) талын түрэг аймгуудын ноёрхлын үе, б) татарууд түрэг аймгуудыг эрхшээлдээ оруулж, татар нэрээр бүгдийг нэрлэх болсон үе, в) Монголчуудын манлайллын үе гэсэн этнологийн гурван үе шатанд хуваан¹⁴ авч үзсэн бөгөөд Төв Азид Түрэг, Татар, Монгол аймгууд ээлжлэн хүчирхэгжиж, аль аймгууд нь хүчирхэг байна, тэр аймгуудын нэрээр бусад нь нэрлэгддэг байсан гэж үзэж болох юм.

"Үүнээс өмнө татарчууд ялагч болсны улмаас бүгдийг татарчууд гэж нэрэлсэнтэй адил юм. Татарчууд бас Араб, Хиндустан, Хятадад бас нэр алдартай байна", "Одоо болохоор Хятад, Зүрчидийн хүмүүс нанхиад, уйгар, кипчак, туркмен, харлуг, калач бүх олзлогсад мөн монголчуудын дунд өссөн тажик хүмүүсийг монголчууд гэж нэрлэх болов. Энэ бүх угсаатны нийлбэр өөрсдийн сүр, нэр төрийн хувьд өөрсдийгөө монголчууд гэж нэрлэх нь ашигтай гэж үзэж байна. Үүнээс урьд өмнө л татар хүчтэй хүчирхэг байсны улмаас иймэрхүү явдал мөн байжээ. Энэ шалтгаанаар Хятад, Хинд, Синд, Чин, Мачины нутагт Хиргис, Келар, Башкир оронд, Дешт-и-Кипчакт умар зүгийн нутагт араб аймгуудад Сири, Египет, Марроко (магриб)-т бүх түрэг аймгийг татарчууд гэж нэрлэдэг байв"¹⁵ гэсэн "Судрын чуулган"-ы мэдээнүүдээс үзэхэд тэдгээр Монгол угсааны аймгуудыг Татар хэмээн нэрлэж байсан нь тодорхой байна. Тэгэхээр хэдий үеэс "Монгол" хэмээх нэр угсаатны нэрийтэл болж, монголчуудын ерөнхий нэрийтэл болсон бэ?, хэдийд монгол угсааны аймгуудыг

⁸ Talat Tekin, Orhon yazitlari Kultigin, Bilge kagan, Tonyukuk. Stambul, 1988

⁹ Малов С.Е. Памятники Древнетюркской письменности монголии и киргизии. М.-Л., 1959, с. 31, 39

¹⁰ Шинэхүү М. Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал. УБ., 1975. 75-76, 91 дэх тал

¹¹ Кляшторный С.Г. Государства татар в Центральной Азии /дочингисова эпоха/. Mongolica. К 750-летию "Сокровенного сказания". М., 1993 с.141

¹² Васильев Д.Д. Корпус тюркских рунических памятников бассейна Енисея. Л., 1983, с.34, 71

¹³ Кызласов И.Л. Рунические письменности евразийских степей. М., 1994. с.189.191

¹⁴ Кляшторный С.Г. Государства татар в Центральной Азии /Дочингисова эпоха/. Mongolica. К 750-летию "Сокровенного сказания". М., 1993. с.140

¹⁵ Рашид-Аддин. Дурьдсан зохиол. 67 дахь тал

“Татар” хэмээн нэрийтэж байсан бэ?, хэдий үед Татарууд үлэмж хүчирхэг, нэр алдартай байж, бүгдийг “татарчууд” хэмээн нэрлэж байсан бэ? гэдэг асуулт гарч ирж байна. IX зууны эхэн үе гэхэд Татарын ханлиг Төв Азийн улс төрийн амьдралд идэвхитэй оролцдог хүчирхэг улс төрийн хүчин болсон байсан нь дараа дараагийн үйл явдлуудаас харагдаж байна.

Тувагийн Хербис Баарын (“Кюлюг Йиге”-ийн) руни бичгийн дурсгалд “Хорин долоон настайдаа өөрийн улсын төлөө токуз-татартай дайтахаар явлаа” гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд уг дурсгалыг VIII зууны I хагаст хамааруулдаг байна. С.Г.Кляшторный Киргиз Татарын энэ дайныг 842 онд болсон гээд “Енисейн руни бичигт дурьдагдсан Кюлюг Йиге баатарын оролцсон 842 оны Кыргыз-татарын дайн нь урьд нөлөөгүй байсан киргиз, татар болон кидан нар улс төрийн тавцанд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх болж, IX-X зууны Төв Азийн харилцааг тодорхойлох болсон шинэ нөхцөл байдлын илэрхийлэл болсон” хэмээн тэрээр дүгнээд “Татар улс Сучжоугаар төвлөрөн, Ганьсу, Дорнод Туркестаны нутагт” оршин байсан гэсэн Гамильтоны үзлийг дэмжин, “IX-XII зуунд Ганьсу, Дорнод Туркестаны нутагт Татар улс оршин тогтнож байсан” гэжээ. Үнэхээр тухайн үеийн Төв Азийн улс төрийн нөхцөл байдлыг дүгнэн үзвэл Киргиз, Татар, Киданчууд Төв Азид тэргүүлэх байр суурь гүйцэтгэх болсон байна. 842 оны үйл явдалтай холбогдуулж, Хятадын сурвалж бичигт Ли Дэюя түшмэлийн захидалд “Татарууд Киргизийн дайсан ба Уйгарын сүүлчийн хааны холбоотон” хэмээн анх Татаруудыг тэмдэглэснийг дээрх руни бичигт дурдагдаж буй Киргиз Татарын дайнтай холбогдоно гэж судлаачид үздэг. Энэ нь Татар хэмээх нэр аймаг, угсаатны нэрээр Хятад сурвалжид 842 онд анх тэмдэглэгдсэн гэж Ван Го Вэйн судлан тогтоосонтой таарч байна.

Киргизүүд Монгол нутагт хэдийд, хаагуур ноёрхлоо тогтоож, Монгол нутаг дахь нүүдэлчдийн түүх, хүн амын угсаажилтанд ямар үүрэг гүйцэтгэснийг нарийвчлан тодруулах нь Татарын түүхийг тодруулахад чухал учир холбогдолтой. Киргизүүдийг Хятан нар монгол нутгаас шахан гаргаагүй бөгөөд тэд яагаад Монгол нутгаас явсныг одоо хүртэл оновчтой тайлбарлаж чадахгүй байна. Энэ талаар “Монгол улсын түүх”-ийн тэргүүн ботид “Киргизүүд нь ийнхүү Төв Азийн ихэнх нутгийг эрхшээлдээ оруулсан ч тэнд удаан ноёрхож чадсангүй. Өмнө нь Төв Азид ноёрлоо тогтоож байсан улс гүрнүүд Монгол орны төв нутаг Орхон голын хөндийд төвлөн төр улсаа байгуулж байсан бол Киргисүүд энэ уламжлалыг дагасангүй. Тэд өрөөс энэ нутагт суурьшин идээшихийг эрмэлзээгүй бололтой”¹⁶ гэжээ. Харин Л.Н.Гумилев үзэж байгаагаар X зуунд Монголын тал нутаг “цөл” болж, Түрэг хэлтэн ард түмэн түүний хязгаар руу нүүдэллэж, харин “X зууны эцсээс тал нутагт Амур хавиас дахин суурьшиж эхэлсэн”¹⁷ бол Е.И.Кычановынхоор Монголчууд “Эргүнэ гүн”-ээс гарч ирж Түрэгүүдийг Монгол нутгаас шахан гаргасан¹⁸ ажээ. Ийнхүү Киргизүүд Төв Азид байсан цаг хугацаа болон энэ нутгийг орхиж явсан шалтгааныг олон янзаар тайлбарладаг. Киргизүүд Уйгурын хаант улсыг мөхөөн, Киргиз улсыг байгуулан, улмаар Төв Азид дангаар ноёрхохыг зорьсон боловч тэдний энэ зорилгод Монгол угсааны аймгуудаас бүрдсэн “Татарын ханлиг” гол саад болсоноор төдийлөн амжилтанд хүрээгүй гэж үзэх нь түүхэн үнэнд илүү нийцнэ. Үнэхээр энэ үед Киргиз, Хятанаас гадна тэдэнтэй өрсөлдөхүйц улс төрийн хүчин Төв Азид гарч ирсэн нь Татарууд байсан байна. Киргизүүд Монгол нутагт, ялангуяа дорнод Монголд ноёрхлоо тогтоож чадаагүйг болон урьдын уламжлалыг даган төв Монгол Орхоны хөндийгөөр төвлөн төр улсаа байгуулаагүйг “Киданчууд Монгол нутгаас шахсан”, “энэ нутагт суурьшин идээшихийг эрмэлзээгүй”, “эдийн засгийн шалтгаантай”, “Монгол нутгийн уур амьсгалд зохимж муутай байсан”-аас болсон

¹⁶ Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ., 2003. 348 дахь тал

¹⁷ Гумилев Л.Н. В поисках вымышленного царства. М., 1992, с.52,54,75

¹⁸ Кычанов Е.И. Монголы в VI-первой половине XII в. Дальний Восток и соседние территории в средние века: История и культура Востока Азии. Новосибирск, 1980, с.139

гэх нь учир дутагдалтай бөгөөд Татар аймгуудын эсэргүүцэл тэмцэлтэй холбон тайлбарлах нь үнэнд илүү ойртох бизээ.

Ийнхүү Уйгурын хаант улс мөхсөн 840-өөд оны үеэс Татарууд хүчирхэгжин Төв Азид Хятан, Киргизүүдтэй өрсөлдөхүйц улс төрийн хүчин болж гарч иржээ. Улмаар Киргизүүдтэй дайтан "Татарчууд ялагч болсоны улмаас бүгдийг татарчууд гэж нэрэлсэн" төдийгүй "Араб, Хиндустан, Хятадад бас нэр алдартай", "Хэт их сүр, нэр хүндтэй байсан" үе нь 840-өөд оноос Хятан гүрэн монголын дорнод хэсгийг хяналтандаа авсан 923 он хүртэлх үед холбогдох бөгөөд энэ үеийг "Татарын хаант улс"-ын үе гэж нэрлэж болно хэмээн үзэж байна.

Хятан гүрний түүхийн хятад хэлээрх мэдээ хэрэглэгдэхүүнээс үзвэл, Хятаны цэрэг 923, 924 онд монголоос байлдан эзэлсэн газрын баруун зах нь Алтайн уул хүрч, хойд зах нь Хэрлэн голд тулж байжээ. Хэрлэн голоос хойшх газрыг Хятан гүрний цэрэг эзэлсэн мэдээ байхгүй бөгөөд Хэрлэн голоос хойшх монгол аймгууд Хятаны эрхшээл нөлөөнд ороогүй гэж үзэж болно. Нөгөө талаар Х зууны сүүлч хүртэл Зү-бү аймгууд Хятаны хараат байдлын тэмдэг болгож, их төлөв адуу малаар алба өргөх төдийгөөр хазгаарлагдаж байжээ. Монгол-Татарууд Хятаны хараат болсон боловч, үнэн хэрэгтээ бие даасан бодлого явуулж, Хятаны нөлөө төдийлөн их байгаагүй бололтой. Ямар ч байсан Хятанчууд монгол нутагт орж ирэхэд Киргизүүд монгол нутагт нутагт байгаагүй нь тодорхой байна.

Хятан улсын нөлөө Монгол нутагт хэр их байсан, хэдийд Хятанчуудын ноёрхлоос Монгол угсааны аймгууд гарсан зэрэг нь төдийлөн тодорхойгүй байна. Монгол угсааны аймгууд Хятан улсын хараат байсан ч тэдний нөлөө төдийлөн их байгаагүй бололтой. Хятан улсын хараат болсоноор Татарын хаант улс задарчээ. Гэвч XI-XII зуун гэхэд Татарын гол цөм мөхлөг нь Хөлөн Буйр нуур орчмоор нутаглан Татарын ханлиг хэлбэрээр оршин Төв Азийн түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгэсээр байсан.

Энэ бүгдээс үзэхэд, Түрэг (555-745), Уйгур (745-840)-ын хаант улсын үед монгол угсааны аймгууд "Татар" хэмээн нэрийдэн тэдний бүрэлдэхүүнд багтаж явсан нь сурвалжийн мэдээгээр нотлогдож байна. Харин Уйгур улсын хүчин сулран доройтох үед Татарууд улам бүр хүчирхэгжин, Уйгурыг мөхөөсөн Енисейн Киргизүүдтэй дайтан ялж, "Татарын хаант улс" (840-923 он)-ыг байгуулжээ. 840-923 оны үед оршин байсан (илүү удаан оршин тогносон ч байж ч магадгүй) Татаруудын байгуулсан улсын үеийг **"Монгол-Татарын хаант улс"** гэж нэрлэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Монгол-Татарын хаант улс ийнхүү гурван зуу орчим жилийн Түрэг угсааны аймгуудын ноёрхлыг зогсоон, Монгол угсааны аймгуудын хүчирхэгжлийн эхийг тавьж, дэлхий дахинд "Монголын үе" хэмээн нэрлэгддэг XIII-XIV зууны Монголчуудын хүчирхэгжлийн үндсийг тавьсан билээ.

Abstract: A chronology of ancient Central Asian states is believed in other way. Developments of research on Chinese historical sources give us advantages to look ancient history of steppe-nomads in different types. Especially, chronologies of Xiongnu and Xiangbei states are taking in new periods which contain links between ancient states and aimags. Those states and aimaks may have same origin and united history as research is still going. The years of Mongol-Tatar kingdom 842-923/924 is presented by the author who condemns "the lost years".